



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 15/1, Утас: 26-08-55, Факс: (976-51) 26-37-39,
E-mail: gpo@prokuror.mn

2015-07-01 № 1/2413

танай _____ -ны № _____ -т


**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА З.ЭНХБОЛД ТАНАА**

Прокурорын байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Улсын Ерөнхий прокурор эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар жилд нэгээс доошгүй удаа Улсын Их Хуралд мэдээлнэ.” гэж заасны дагуу мэдээлэл бэлтгэж, түүнд тусгагдсан зарим асуудлыг шийдвэрлүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хамт өргөн мэдүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ **М.ЭНХ-АМГАЛАН**



0503999

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Прокурорын байгууллагаас 2014 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнд хүргэх зорилт тавьж, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, прокурорын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгох, прокурорын хяналтын ажлыг зохицуулсан эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаандаа програм хангамжийг хөгжүүлэх, сургалтын хамрах хүрээг өргөжүүлж, чанар, үр дүнг дээшлүүлэх, прокурор, туслах ажилтнуудын орон тоог нэмэгдүүлж, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэгт бодлогын түвшинд анхаарч ажиллалаа.

“Шүүх эрх, мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, хөтөлбөр”-ийн хүрээнд Улсын Ерөнхий прокурорын санаачлагаар 2014 онд “Төв, орон нутгийн хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн”-ийг аймгуудад зохион байгуулж, шүүх эрх мэдлийн болон хуулийн байгууллагуудын баримталж буй нэгдсэн бодлого, чиглэл, зорилт, өөрчлөлт шинэчлэлтийн талаар орон нутгийн хуулийн байгууллагад ажиллаж байгаа шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч болон хуулийн байгууллагын захиргааны ажилтнуудад мэдээлэл өгөх, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, орон нутагт тулгарч буй бэрхшээлийг хамтран шийдвэрлэх, тэднээс гаргасан санал хүсэлтийг сонсож, цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх бодлого боловсруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

Миний бие Улсын Ерөнхий прокуророор томилогдсоноос хойшхи хугацаанд Улсын Ерөнхий прокурорын газрын бүтцэд зарим өөрчлөлт хийж, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн чиг үүргээс шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс прокурор оролцох үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахад баримтлах бодлогыг тодорхойлох, улсын яллагч нарыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах үндсэн чиг үүргийг салгаж, уг чиг үүргийг хэрэгжүүлэх Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийг, мөн прокурорын байгууллагын үйл ажиллагаа, удирдлагын баримт бичгийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж, цахим мэдээллийн систем, мэдээлэл дамжуулах сүлжээний ажиллагаа, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, харьяа прокурорын газруудын удирдлага, зохион байгуулалтын ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах чиг үүрэг бүхий Дүн шинжилгээ, судалгаа, хяналт шалгалтын хэлтсийг тус тус шинээр байгуулан ажиллаж байна.

Прокурорын хяналтын ажлын давхардлыг арилгах, дээд шатны прокурорын хяналтын чиг үүргийг оновчтой болгох зорилгоор “Прокурорын байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэх заавар”-т өөрчлөлт оруулав.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий зарим байгууллагуудаас гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харъяаллыг 2015 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн А/67 дугаартай тушаалаар шинэчлэн тогтоож, батлан мөрдүүлж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөний халдашгүй байдлыг хангах зорилгоор гэмт хэрэгт холбогдсон этгээдийн гадаадад зорчих эрхийг хязгаарлах буюу хилийн хориг тавих асуудлыг шийдвэрлэж байсан журмыг өөрчилж, Улсын Ерөнхий прокурорын 2015 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн А/52 дугаар тушаалаар “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажилд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг дагаж мөрдөх аргачилсан заавар”-т өөрчлөлт орууллаа.

Эрүүгийн нөхцөл байдлын талаар:

Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг, зөрчлийн гаралт өсч, үйлдэх арга нь улам нарийсч, хүч хэрэглэсэн, онц хэрцгий аргаар хүний амь насанд халдсан, аймаг, орон нутаг дамжсан, зохион байгуулалттай, гэр бүлийн хүчирхийлэл дор үйлдэгдсэн ноцтой гэмт хэргүүд цөөнгүй гарч байна.

Улсын хэмжээнд 2014 онд эрх бүхий байгууллагын хүлээн авч шалгасан гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13678 буюу 13,9 хувиар өссөн байна.

2013 онд 25362 гэмт хэрэг үйлдэгдэж, үүнд 22286 хүн холбогдож байсан бол 2014 онд 27318 гэмт хэрэг үйлдэгдэж, 23737 хүн холбогдон шалгагдсан бөгөөд үйлдэгдсэн хэрэг өмнөх оныхоос 7.7 хувиар, гэмт хэрэг үйлдсэн хүний тоо 6.5 хувиар өсчээ.

Прокурорууд 2014 онд 46280 захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан материал хянасан нь өмнөх оноос 6.8 хувиар, үндэслэлгүйгээр захиргааны арга хэмжээ авсан 207 шийдвэрийг хүчингүй болгосон нь 5.5 хувиар, 216 шийдвэрт өөрчлөлт оруулсан нь 3.3 дахин өсчээ.

Улсын хэмжээнд 1984-2014 оны хооронд түдгэлзүүлсэн 14383 эрүүгийн хэргийн 13704 буюу 95.2 хувь нь яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаа, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хөрөнгө битүүмжлэх, нуугдмал хөрөнгийг илрүүлэх ажиллагаа хангалттай түвшинд хийгдэхгүй байна. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад бусдын зөрчигдсөн эрхийг сэргээх, торгох, эд хөрөнгө хураах ялын биелэлтийг хангуулах, хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор сэжигтэн, яллагдагч болон хуулиар тэдний төлөө эд материалын хариуцлага хүлээвэл зохих хүмүүсийн эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа явуулсны үр дүнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад 24,2 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилж, 63,1 тэрбум төгрөгийн хохирол нөхөн төлүүлжээ.

2015 оны эхний 5 сарын байдлаар Прокурорын байгууллагаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нийт 23835 хэрэгт хяналт тавьж ажилласнаас 8741 хэргийг хэрэгсэхгүй болгож, 3031 хэргийг шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлсний дотор хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан 9092 хэргээс 2609 хэрэг буюу 29,0 хувьд нь хялбаршуулсан журмаар хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан байна. Хэргийг аль болох богино хугацаанд, байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдод зардал чирэгдэл багатай шийдвэрлэхэд анхаарч байгаагийн дүнд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдэж буй хэргийн хувь жил тутам өсч байна.

2014 онд анхан шатны шүүхээр 6193, давж заалдах шатны шүүхээр 1233, хяналтын шатны шүүхээр 422, нийт 7848 хэргийг хянан шийдвэрлэхэд прокурор оролцож санал дүгнэлт гаргаж, шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч нийт 444 эсэргүүцэл бичсэний 64.1 хувь нь биелсэн байна.

Төрийн байгууллагаас иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийг төлөөлөн прокурорыг оролцуулахаар 78 хүсэлт гарсны дагуу анхан шатны иргэний шүүх хуралдаанд төрийн ашиг сонирхлыг хамгаалан оролцож 686,9 сая төгрөгийн үнийн дүн бүхий хүсэлтийг хангуулан шийдвэрлэсэн байна.

2015 оны эхний 5 сарын байдлаар эрүүгийн 3113 шүүх хуралдаанд прокурор оролцоод байна.

Шүүхээс ял шийтгүүлсэн ялтныг хуулиар тогтоосон нөхцөл, журмын дагуу ял эдлүүлэх, ял завшуулахгүй байх, ялтны эрхийг нь хангах, тэднийг нийгэмшүүлэх, хорихоос өөр төрлийн ялын биелэлтийг нэмэгдүүлэх, албадах байрны ахуй нөхцлийг сайжруулахад ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтыг чиглүүлэн ажиллав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудад 2014 оны жилийн эцсийн байдлаар нийт 6527 ялтан ял эдэлж байснаас баривчлах ялтай 127, насанд хүрээгүйчүүдийн хорих ангид 27, жирийн дэглэмтэй хорих ангид 3408, чанга

дэглэмтэй хорих ангид 2618, онцгой дэглэмтэй хорих ангид 295, гянданд 79 /үүнээс 30 жилтэй 34/ ялтан тус тус ял эдэлж буй судалгаа гарсан байна.

Хорих ял эдэлж буй нийт ялтны 6207 буюу 95 хувь нь эрэгтэй, 320 буюу 4.9 хувь нь эмэгтэй, 30 буюу 0.4 хувь нь насанд хүрээгүй ялтнууд байна.

Шүүхээр 2327 ялтны шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлж, ялтан шилжүүлэх олон улсын гэрээний дагуу 2014 онд гадаад улсад ял эдэлж байсан Монгол Улсын 3 иргэнийг шилжүүлэн авч, Монгол Улсад ял эдэлж байсан гадаадын 5 ялтныг тухайн улсад нь шилжүүлэх ажиллагааг гүйцэтгэв.

Улсын хэмжээнд 2014 онд хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн 11157 ялтан ял эдэлж байгаагаас 285 буюу 2.6 хувь нь торгох, 430 буюу 3.9 хувь нь албадан ажил хийлгэх, 1399 буюу 12.5 хувь нь тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, 599 буюу 5.4 хувь нь эд хөрөнгө хураах ял шийтгүүлсэн ялтан байна.

Торгох ялын биелэлт 2014 онд 74.2 хувьтай, эд хөрөнгө хураах ялын биелэлт 90.7 хувьтай байв.

2015 оны эхний 5 сарын байдлаар баривчлах, хорих ял эдэлж байгаа 6660, хорихоос өөр төрлийн ял эдэлж байгаа 7123 ялтан байна.

Прокурорын байгууллага эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд төрийн зүгээс анхаарч дэмжих, шийдвэрлэвэл зохих асуудал цөөнгүй байна. Тухайлбал:

1. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 476 прокурор ажиллаж байгаагаас 217 прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцож байна.

Прокурорын батлагдсан орон тоо 2012 онд 435, 2013 онд 459, 2014 онд 476 болж сүүлийн 3 жилд 41 орон тоогоор нэмэгдсэн нь нийт хяналт тавьж шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 66342-оос 96843 болж 31.5 хувь, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоо 33856-аас 39559 болж жилд 7-9 хувь, хянасан захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтийн материал 42 хувь тус тус өссөнтэй харьцуулахад хангалтгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нийт 22 хорих ангид 2014 онд 6527 ялтан ял эдэлж байсан ба мөн онд онцгой дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа ялтны тоо 13.5 хувиар, баривчлах ялаар шийтгүүлсэн ялтны тоо 8.6 хувиар тус тус өссөн, хорихоос өөр төрлийн ялаар 2014 онд 11157 хүн шийтгүүлсэн нь 2013 оноос 10 хувиар өссөн ба ял эдлүүлэх ажиллагаанд улсын хэмжээнд нийт 44 прокурор хяналт тавин ажиллаж байгаа нь захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд

хяналт тавих ажлыг үндсэнд нь орхигдуулж зөвхөн гомдол гарснаар хянаж буй нь орон тоотой холбоотой байна.

Прокурорын ажлын ачаалал нэмэгдэж Үндсэн хууль болон Прокурорын байгууллагын тухай хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа тул прокурорын орон тоог нэмэгдүүлэх саналтай байна.

2. Прокурорын цалин 2011 оноос хойш нэмэгдээгүй бөгөөд анхан шатны хяналтын прокурорын үндсэн цалин 750000 төгрөг, Улсын Ерөнхий прокурорын туслах, хэлтсийн даргын цалин 956859 төгрөг байгаа юм. Цалин бага байгаагаас прокуроруудын дунд өндөр цалинтай ажилд орох сонирхол давамгайлан, тогтвор суурьшилтай ажиллах байдал алдагдаж, цаашид дадлага, туршлагатай чадварлаг боловсон хүчнээр дутагдах асуудал гарахад нөлөөлж байна.

Прокурорын одоогийн цалин нь тэдний хараат бус, шударгаар шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлөхүйц хэмжээнд байгаа тул энэ асуудлыг даруй шийдвэрлэж прокурорын цалинг нэмэгдүүлэх.

3. “Шүүх байгуулах тухай хууль”-д нийцүүлэн 2014 онд Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн, салбар нэгжүүдийн чиг үүргийг шинэчлэн баталж, Нийслэлийн 6 дүүргийг нэгтгэн 2 дүүрэг болгож төвлөрүүлснээр Дүүргийн прокурорын газруудын ажлын ачаалал нэмэгдэж, албан конторын асуудал хүндрэлтэй болж, нэг өрөөнд 2-4 прокурор, туслах ажилтны хамт ажил үүргээ гүйцэтгэж байна.

Тухайлбал: Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй дүүрэг хариуцсан прокурорын газруудад албан конторын барилга шаардлагатай байна.

4. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанд зөвхөн Ерөнхий прокурор эсэргүүцэл бичдэг болсон хуулийн заалт нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй төдийгүй яллах тал чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах цаг хугацаа, нөхцөл боломжийг хаасан заалт болсон тул Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулж, улсын яллагч эсэргүүцэл бичдэг байсан өмнөх зохицуулалтыг бий болгох.

5. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын үнэлгээ хийлгэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох. Үүнд:

- Эд зүйлсийн шинж чанар, онцлог байдлыг харгалзан төрийн, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт, үнэлгээ гаргадаг эрх зүйн орчныг бий болгох;

- Улсын хэмжээнд өдөр тутмын ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүний зах зээлийн мэдээллийн санг бий болгож, эдгээр зүйлсийн үнэлгээг сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх Үнэлгээний комисс гаргаж байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

- Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн “Хөрөнгийн үнэлгээ хийх үндэслэл” гэсэн 5 дугаар зүйлийн 5.1.2 “хуульд тусгайлан заасан тохиолдолд эрх бүхий этгээдийн шийдвэрээр хөрөнгийн үнэлгээ хийнэ” гэсэн хэсгийн “хуульд тусгайлан заасан” гэснийг тодруулан “Эрүүгийн байцаан шийтгэх хууль” гэж өөрчлөх, мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу хохирлын үнэлгээ хийсэн тохиолдолд үйлчилгээний хөлсийг байцаан шийтгэх ажиллагааны зардал гаргуулах журмаар авах, мөн хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээж оролцох тухай зохицуулалтуудыг тус тус нэмж оруулах;

- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүхийн байгууллагын жил бүрийн төсвийн төсөлд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зардлыг хүрэлцэхүйц хэмжээгээр нарийвчлан тусгаж байх шаардлагатай байна. Эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч байгууллагуудын төсөвт энэ зардал тусгагдаагүйн улмаас эрүүгийн хэргийг шуурхай шийдэх боломжгүй болж, улмаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт хангагдахгүйд хүрч байна.

Тухайлбал: Мөрдөн байцаах газрын Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтэс 2014 онд байгаль орчинд учирсан хохирлыг тооцуулахаар 18 эрүүгийн хэрэгт шинжээч томилж дүгнэлт гаргуулахад 400,0 сая төгрөгийн төлбөр гарсан, 2015 оны эхний 5 сард 9 эрүүгийн хэргийн шинжээчийн зардалд 178,1 сая төгрөг шаардагдаж байгаа боловч байгууллагын төсөвт тусгагдаагүй зардал тул шийдвэрлэх боломжгүй байна.

6. Эрүүгийн хэрэгт тусгай мэдлэг шаардсан асуудлаар дүгнэлт гаргуулах зорилгоор шинжилгээ хийлгэх, шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх тохиолдолд хүндрэл учирч байна. Тухайлбал:

- Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журам зөрчих, уул уурхай, барилга, түүнчлэн тэсэрч дэлбэрэх аюул гарч болзошгүй үйлдвэр, бусад аж ахуйн нэгж, байгууллагад аюулгүй ажиллагааны журам зөрчсөн эсэхийг тогтоож дүгнэлт гаргах байгууллага, албан тушаалтан байхгүй байна.

Шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх тохиолдолд зардал өндөр байдгаас төлж чадахгүй, дүгнэлтээ авч чаддаггүй, улмаар хэрэг шалгах ажиллагаа удааширдаг, нөгөө талаас шинжилгээний байгууллагаас гадуурх тухайн байгууллага, албан тушаалтан эрүүгийн хэрэгт шинжилгээ хийхээс татгалздаг нь ажилд хүндрэл учруулж байна. Тухайлбал: Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт хийгдэх шинжилгээг хийх техник хэрэгсэл Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнд байдаггүйгээс Гаалийн ерөнхий газрын

лабораториор хийлгэх шаардлага гардаг ба энэ нь өртөг өндөртэй байдаг. Мөн аж ахуйн эсрэг гэмт хэрэгт аудитын дүгнэлт гаргуулахад төлбөрийн асуудал тулгардаг.

Иймд эдгээр асуудлуудыг шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, эдийн засгийн нөхцлийг нь бүрдүүлж өгөх шаардлагатай байна.

7. Гадаад харилцаа хөгжихийн хэрээр гадаадын иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрт, Монгол Улсын иргэд гадаадад гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдах тохиолдол ихэсч байна. Монгол Улсын Засгийн газраас гадаадын зарим улстай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний зохицуулалт нь дутмаг, өнөөгийн харилцааны шаардлага хангахгүй, зарим улс оронтой харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй зэргээс шалтгаалан зарим хэргийн гадаадад хийгдэх байцаан шийтгэх ажиллагаанд хүндрэл учирч байна.

Мэдээлэлд дурьдсан санал, хүсэлтийг шийдвэрлэх талаар анхаарал хандуулж өгөхийг хүсье.

----- оОо -----